



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ  
2021-2024 он**

Шадар сайдын тушаал:

Дугаар . . . . . 2021 оны 11 сарын 29-ны өдөр.

Төлөвлөгөө баталсан:

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
/Төсвийн ерөнхийлөн захирагч/



С.АМАРСАЙХАН

Төлөвлөгөө боловсруулсан:

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ГАЗРЫН ДАРГА  
/Төсвийн төвлөрүүлэн захирагч/



Б.БИЛГҮҮН

## АГУУЛГА

<b>1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b> .....	3
1.1 Стандартчилал, тохирлын үнэлгээний салбарын үүсэл, хөгжил .....	4
1.2 Хэмжил зүйн салбарын үүсэл, хөгжил .....	5
1.3 Сорьцын хяналтын албаны үүсэл, хөгжил .....	8
1.4 Салбарын өмнө тулгамдсан асуудлууд .....	9
1.5 Стратеги боловсруулах хэрэгцээ, шаардлага .....	11
<b>2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ</b> .....	11
<b>3. АЛСЫН ХАРАА</b> .....	15
<b>4. ЭРХЭМ ЗОРИЛГО</b> .....	15
<b>5. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ</b> .....	15
5.1 Гадаад орчны шинжилгээ .....	16
5.2 Дотоод орчны шинжилгээ .....	18
<b>6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО</b> .....	27
<b>7. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН</b> .....	28
<b>8. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ</b> .....	29
<b>9. ХАВСРАЛТ</b> .....	30

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**Зорилго, зорилт.** Стандарт, хэмжил зүйн газрын стратеги төлөвлөгөөний зорилго нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний чиглэлээр гарсан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Уг зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж, төлөвлөгөөнд тусгалаа. Үүнд:

- Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх;
- Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хамрах хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх, ерөнхий чиг үүрэг, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлох;
- Өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж давуу болон сул талуудыг тодорхойлох, эрэмбэлэх;
- Стратегийн зорилго, зорилт, уялдаа холбоо, нийтлэг асуудлыг судлах, хүрэх үр дүнг тооцох;
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын үйл ажиллагааны үялдааг хангах;

**Стратеги төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим.** Төлөвлөгөөг “УХААЛАГ” буюу зорилго тодорхой байх, “ХЭМЖИЖ БОЛОХУЙЦ” байх, “ХҮРЧ БОЛОХУЙЦ” байх, “БОДИТОЙ” байх, “ЦАГ ХУГАЦААТАЙ” байхаар боловсруулах зарчмыг баримталсан.

**Хамрах хүрээ.** Монгол Улсын хэмжээнд стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй болон сорьцын хяналтын үйл ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөн 2021-2024 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.

**Хүрэх үр дүн.** Стратеги төлөвлөгөө амжилттай хэрэгжсэнээр стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрэлдэн, цахим засаглалыг хөгжүүлэх замаар нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Манай оронд стандартчилал, хэмжил зүйн ажил нь 1921 оноос хойш улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилт, удирдлагын арга хэлбэртэй нягт уялдаатай, тодорхой үе шаттай хөгжиж ирсэн.

Монгол Улсын үндэсний стандартчилал нь хөгжлийнхөө үе шат болгонд тодорхой зорилтыг шийдвэрлэж, улс орны худалдаа, эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээгдэхүүний чанар дээшлүүлэхэд зохих түлхэц үзүүлсээр ирсэн.

Тус улсад хэмжилзүй нь худалдаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, холбоо, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах салбарын хөгжлийн хэр хэмжээгээр

үүсэн хөгжиж, аливаа үзэгдэл, үйл ажиллагаа, түүний үр дүнгийн тоо, чанарын үзүүлэлтийг үнэлж дүгнэх чухал хэрэглүүр болж байна.

### **1.1 Стандартчилал, тохирлын үнэлгээний салбарын үүсэл, хөгжил**

Эдийн засагт аж үйлдвэр дорвитой байр эзэлж чадаагүй 1930 он хүртэлх үед аж ахуйн үндсэн салбар мал аж ахуйн түүхий эд ноос, ноолуур, өлөн гэдэс, арьс шир болон ангийн үсийг гадаадад гаргах нь улс орны импортын хэрэгцээг хангах, төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх гол арга зам болж байв.

БНМАУ-ын Ардын эд хэрэглэхүүнийг нийлүүлэх Хоршоодын төв холбоо, Энгийн худалдаачид лугаа харилцан худалдаалах Улсын худалдааны газар хамтран улс хувьсгалын 15 жилийн ойд зориулан 1936 онд ЗХУ-ын мал аж ахуйн бүтээгдэхүүний хялбарчилсан стандартыг үндэс болгож, “Түүхий эд, ангийн үсний нэгтгэсэн заавар”-ыг хэвлэн гаргажээ. Энэ заавар нь стандарттай дүйцэхүйц, түүний үүрэг, зорилгыг хангасан, албан ёсны баримт бичиг байв.

***1961 он хүртэл стандартчиллын ажил нь нэг талаас эрх зүй, зохион байгуулалт, удирдлагын талаасаа бүрдэл болж, нөгөө талаас нийгмийн хэрэгцээ шаардлагаас үндэслэн эрчимтэй хөгжих шинэ шатанд орсон байна.***

1973 онд бүтээгдэхүүний чанар сайжруулах асуудал хэлэлцсэн улсын зөвлөгөөнийг хийлгэж, түүний шийдвэрийг биелүүлэх талаар Сайд нарын Зөвлөлийн 403 дугаар тогтоолд заахдаа: 1974 оны 1 дүгээр сараас эхлэн жил бүр нийт бүтээгдэхүүнийг стандарт, технологийн заавартай болгох, тэдгээрийг дахин хянаж батлуулах, бүртгүүлэх, хэвлүүлж олшруулах, нэвтрүүлэх, хэрхэн мөрдөж байгааг шалгаж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах календарьчилсан график гаргаж, биелэлтэд тогтмол хяналт тавьж байхыг салбарын яамдад даалгажээ.

***Ийнхүү чанар, стандартчиллын ажлын уялдааг хангаж хөгжүүлсний үр дүнд 1961-1975 онд УСТ 1889, ТН 284 батлагдаж, эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүний 90 гаруй хувь нь стандарттай болж, “үйлдвэрлэж байгаа бүх бүтээгдэхүүнийг стандарттай болгох” зорилт үндсэндээ биелсэн байна. Энэ зорилт нь хэдийгээр тоон үзүүлэлтийн зорилт байсан боловч тухайн үеийн аж ахуйн удирдлагын систем, нөхцөл байдал, манай стандартчиллын онол, арга зүйн хөгжлийн түвшин, боловсон хүчний боломж зэрэгтэй уялдуулж үзвэл томоохон ололтын нэг байжээ.***

1988 онд Үнэ, стандартын улсын хороог татан буулгаж, үнийн асуудлыг Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хороонд шилжүүлэн, Сайд нарын Зөвлөлийн дэргэд Улсын стандартын газар (УСГ)-ыг байгуулав. Тус газар шинэ нөхцөл, шаардлагын дагуу стандартчиллыг боловсронгуй болгох зорилгоор юуны өмнө стандартчиллын дүрмийг өөрчлөн Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 308 дугаар тогтоолоор “БНМАУ-ын стандартчиллын дүрэм” нэртэйгээр батлуулжээ.

**Улсын стандартчиллын бодлогыг 1976-1988 онд хэрэгжүүлж, хөгжүүлэх үе шатанд, ялангуяа 1980-аад он хүртэл эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүнийг стандартчиллын норматив-техникийн баримт бичгээр бүрэн хангах зорилттой ажилласны дүнд 1988 онд нийт бүтээгдэхүүний 98%-ийг стандартчилсан байв.**

1990-ээд оны эхээр зах зээлд шилжиж буйтай холбогдон бүтээгдэхүүний нэр төрөл, гарал үүсэл эрс олширч, бүтээгдэхүүний чанар, хэрэглээний аюулгүй байдлыг хангах явдал нэг тулгамдсан зорилт болов.Энэ зорилтыг ханган биелүүлэхэд чиглүүлэн төр, засгаас дэс дараатай хэд хэдэн арга хэмжээг авсны дотор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөс 1994 оны 3 дугаар сарын 24-ний 01 тоот зөвлөмжөөр “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаадаас ирүүлсэн бараа, бүтээгдэхүүний чанар нь үндэсний стандарт, чанарын шаардлага, эрүүл ахуйн нормд тохирч буй эсэхийг шинжилж, худалдахыг зөвшөөрсөн баталгаатай болгох, хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартчиллын түвшинг олон улсын стандартын жишигт хүргэх” заалт өгчээ.

1995 онд батлагдсан "Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай" шинэ хуулиар дараах объектод заавал мөрдөх стандарт тогтоож байхаар болжээ:

- хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, амьтанд хохирол учруулж болох бүтээгдэхүүн,
- хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын нөхцөлд тавих шаардлага,
- эдийн засаг, нийгмийн чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн.

Эдгээр объектын жагсаалтыг Засгийн газрын 1995 оны 6-р сарын 21-ний 100 дугаар тогтоолоор баталж, түүнд 4 бүлгийн 131 объектыг оруулсан байна.

**2000 онд бүх 3766 улсын стандартад үзлэг хийж, 469 стандартыг хүчингүй болгох, 833 стандартыг хянаж өөрчлөхөөр болсон байна. Түүнчлэн олон улсын дэвшилт стандартыг өргөнөөр үндэсний болгох зэрэг нэлээд ажлыг хийжээ. Эдгээрийн үр дүнд жилд баталсан улсын стандартын тоо 1992 онд 325 байсан нь 2001 онд 375 болж 15%-иар өссөний зэрэгцээ тэдгээрийн түвшин мэдэгдэхүйц дээшилж иржээ.**

## **1.2 Хэмжил зүйн салбарын үүсэл, хөгжил**

1921 онд анх Зөвлөлт Оросын тусламжтайгаар харилцан туслалцах хоршоо хоёр дэлгүүртэй байгуулагдах үед шударга хэмжүүр хэрэглэсэн нь хэмжүүрийн аж ахуйн эхлэл гэж үзэж болно.

1923 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр харьяат комиссын гишүүдийн хуралдааны 34 дүгээр хурлаас Сангийн яаманд хэмжүүрийн байцаагч-түшмэл 1, хэмжүүр засах дархан 2-ын орон тоог баталсан. 1923 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Нийслэл Хүрээний Монгол Ардын Намын бүх гишүүдийн 3 дугаар хурлаас тогтоол гаргаж “Хэмжүүрийг шалгуулж, тэмдэг даруулан, татвар хураалгасны дараа эргүүлэн хэрэглүүлэх эрх олгуулах” тухай заасан зэргээс үзэхэд Монгол Улсад хэмжилзүйн алба үүсэх эхлэл тавигдсан гэж үзэж болно.

1924 онд Улсын анхдугаар Их Хурлаас баталсан анхдугаар Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 14 дэх хэсэг “Аливаа хэмжээ, чигнүүрийг тогтоох” гэж заасан нь тэр үед хэмжүүрийн аж ахуйг хөгжүүлэх, үндэсний хэмжүүртэй болох шаардлагатай байсны нотолгоо гэлтэй.

***1924-1944 онд жин хэмжүүрийн тасаг ажиллаж байсан боловч ажил нь тогтмол биш, цаг үеийн байдлаар явагдаж байсан байна.***

Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 26 дугаар тогтоолоор “Хэмжүүр ба хэмжих хэрэгслийн тухай” хууль баталж, улс ардын аж ахуйн нийт салбарт явуулж байгаа хэмжилд метрийн нэгжийн системийн хэмжүүрийг хэрэглэх, бүх хэмжүүрийг тодорхой хугацаанд заавал шалгуулж, улсын баталгаа авч байх журмыг тогтоох, улсын хэмжээнд хэмжүүрийн аж ахуйд хяналт тавих үүрэг бүхий хэмжүүрийн алба зохион байгуулах зэрэг арга хэмжээ авахыг Ардын Сайд нарын Зөвлөлд даалгажээ.

Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын 54 дүгээр тогтоолоор, Сайд нарын Зөвлөлийн дэргэд “Жин хэмжүүрийн хэрэг эрхлэх хэлтэс”-ийг 10 орон тоотой байгуулж, мөн Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 6-р сарын 16ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Хэмжүүрийн улсын шалгагчийн дүрэм”-ийг баталсан байна.

1944 оны 9 дүгээр сард “Хэмжүүр ба хэмжих хэрэгслийн тухай” хуульд өөрчлөлт оруулж, Сайд нарын Зөвлөлийн харьяа Жин хэмжүүрийн хэрэг эрхлэх хэлтсийг Сангийн яаманд орон тоо, зардлын хамт шилжүүлжээ.

1950-иад онд манай улсад үйлдвэр, аж ахуйн газрууд олноор байгуулагдаж хоорондын тайлан тооцооны болон техник технологийн хяналтын хэмжүүрүүд олширч, тэдгээрт тавих улсын хяналтын системийг сайжруулах шаардлага тулгарч, хэмжүүрийг шалгах болон засварлах цар хүрээ нэмэгдсээр байв. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1955 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 127 дугаар тогтоолоор Сангийн яамны жин хэмжүүрийн хэлтсийг “Хэмжүүр ба хэмжих багаж хэрэгслийн хэрэг эрхлэх газар” болгон хэмжүүр, хэмжих хэрэгсэлд хяналт тавих замаар хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үүргийг хариуцуулжээ.

Сайд нарын Зөвлөлийн 1958 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 399 дүгээр тогтоолоор Улсын төлөвлөгөөний комиссын дэргэдэх Үнэ, стандартын товчоо, Сангийн яамны харьяа Жин хэмжүүрийн хэрэг эрхлэх газар, Худалдааны яамны дэргэдэх Эдийн чанар шалгах газрыг нэгтгэж 1959 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Сайд нарын Зөвлөлийн дэргэд Улсын стандарт, хэмжүүр ба хэмжих хэрэгслийн хэрэг эрхлэх газар (УСХХХХЭГ)-ыг байгуулжээ.

Хэмжүүрийн ажлыг орон нутагт чанартай гүйцэтгэж зардал чирэгдлийг багасгахын тулд Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 144 дүгээр тогтоолоор Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь аймгийн дундын тасгийг Чойбалсан хотод төвлөрүүлэн зохион байгуулж ажиллуулжээ.



**1970-аад онд хэмжүүрийн тоног төхөөрөмж, материаллаг баазыг хөгжүүлэх, хэмжүүрийн аж ахуйн эмх цэгцийг сайжруулах талаар нэлээд арга хэмжээ авч хэрэгжүүлж байв.**

“Олон улсын хэмжлийн нэгжийн “СИ” системийн нэгжүүдийг улс ардын аж ахуйд хэрэглэх тухай” СнЗ-ийн 1979 оны 12-р сарын 29-ны өдрийн 414 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЭЗХТЗ-ийн стандартын зөвлөмжид үндэслэн өөрийн улсын үндэсний стандарт(УСТ 3002-80)-ыг боловсруулан батлуулсан ба “Хэмжлийн нэгжийн “СИ” систем” гэсэн гарын авлага номыг 1981 онд хэвлүүлэн гаргасан. Хэмжлийн нэгжийг эталонноос ажлын хэмжүүрт дамжуулах, шалгалтын схемийн тухай хэмжлийн холбогдолтой олон улсын стандарт зөвлөмжүүдийг УСТ болгон, улс ардын аж ахуйд нэвтрүүлэх ажлыг зохиож байв.

1979 онд хэмжүүр, хэмжих хэрэгслийн улсын хэмжээний бүртгэл-тооллого явуулах ажлыг Сайд нарын Зөвлөлийн захирамжийн дагуу Улсын хэмжилзүйн албанаас зохион байгуулсан бөгөөд үүний үр дүнд тус улсын улс ардын аж ахуйн нийт салбарт 1980 он гэхэд хэмжлийн 17 төрөлд хамаарах, 1000 гаруй нэрийн 900 мянга гаруй ширхэг, 200 гаруй сая төгрөгийн үнэ бүхий хэмжих хэрэгсэл, хэмжлийн тоног төхөөрөмж ашиглагдаж байгааг тогтоожээ.

**Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 8-р сарын 17-ны өдрийн 270 дугаар тогтоолоор “БНМАУ-ын цаг, давтамжийн эталон”-ыг баталсан нь Монгол Улсын хэмжлийн анхдагч эталон төдийгүй, тус улсын хэмжлийн албаны хөгжлийн түүхэнд болсон чухал үйл явдал байв. Энэ эталонноос цагийн дохиог радиогоор тогтмол нэвтрүүлдэг болжээ.**

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 208 дугаар тогтоолоор баталсан “Хэмжлийн нэгжийн үндэсний эталоны хөтөлбөр”-ийг ээлж дараатай хэрэгжүүлж энэ хөтөлбөрийн ажлын хүрээнд цахилгаан хөдөлгөгч хүчний/ЗГ-ын 1999 оны 2 дугаар тогтоол/, эзлэхүүн, багтаамжийн/ЗГ-ын 1999 оны 217 дугаар тогтоол/, температур, нягтын /ЗГ-ын 2001 оны 5 дугаар тогтоол/, цахилгаан эсэргүүцэл, даралтын/ЗГ-ын 2002 оны 19 дүгээр тогтоол/, хувьсах гүйдлийн хүчдэлийн / ЗГ-ын 2003 оны 5 дугаар тогтоол/ улсын эталонуудыг шинээр бий болгож ашиглалтад оруулжээ.

Дээрх эталонуудтай зэрэгцэн цахилгааны өндөр нарийвчлалын электрон тоолуур, дулааны тоолуур шалгаж баталгаажуулах 0.05%-ийн нарийвчлалтай, эталон төхөөрөмж “Эрчим хүчний хэмнэлтийн төсөл”-ийн хүрээнд ЭХУГ-т суурилагдан өнөөг хүртэл ашиглагдаж байна.

Чех улсын “Габриель” фирмтэй хамтран халуун, хүйтэн усны тоолуур шалгаж баталгаажуулах эталоныг 2003 оны 7 дугаар сард ашиглалтад оруулсан бөгөөд одоо цахилгаан чадлын эталон бий болгох техник зохион байгуулалт, судалгаа, туршилтын ажил хэрэгжсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд хэмжлийн 6 төрлөөр нийт 9 эталон бий болгож улсын эталонноор батлуулсан байна.

**Хэмжлийн нэгжийн үндэсний эталон бий болгох арга хэмжээнд 1998-2003 онд нийт 543.5 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс 196.5 сая төгрөгийг гадаадын буцалтгүй тусламжаар, 32.0 сая төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалтаар, 295,0 сая төгрөгийг үйл ажиллагааныхаа зардлыг ихээхэн хэмжээгээр бууруулах арга хэмжээ авсны үндсэн дээр СХТ-ийн өөрийн орлогоос санхүүжүүлсэн байна.**

### **1.3 Сорьцын хяналтын албаны үүсэл, хөгжил**

Монгол улсад 1963 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Улсын банкны ерөнхий хороонд Үнэт металлын чанар шалгах тасаг байгуулагдсанаар сорьц тогтоох, шалгах, магадлах ажиллагаа эхэлсэн түүхтэй.

1970-аад оны дунд үе хүртэл үнэт металл хайлах техник Монголд үндсэндээ

байсангүй зөвхөн Монгол дархны аргаар хөөрөгдөж хайлдаг байлаа. Тийм ч учраас Монгол банк дархчууд болон Зоос гоёлын зүйлийн үйлдвэрт /ЗГЗҮ/ алт олгохдоо байгалийн нунтаг шороон хэлбэрээр нь өгч байсан төдийгүй цэвэршүүлээгүй алтаар бүтээгдэхүүн хийдэг байсан.

1990-ээд оны эхээр улсын болон хувийн хэвшлийн 10 гаруй алтны уурхайтай болсон боловч нэгдсэн алт хайлах цех байсангүй. Тухайн уед Сэлэнгийн Бугантад ажиллаж байсан Монросцветмет нэгдлийн алтны уурхайн хайлах цехэд очиж алтаа хайлуулах шаардлага гардаг. Тухайлбал: Баянхонгороос Монголболгарметалл үйлдвэрийн металлыг Улаанбаатар хотод онгоцоор авч ирээд дахин Сэлэнгэ рүү очиж хайлаад буцааж авч ирээд сорьц тогтоох шинжилгээнд өгдөг үе байлаа.

Монгол Улсын Засгийн газрын “Сорьцын хяналтын албыг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний” тухай 2015 оны 188 дугаар тогтоолын дагуу Сорьцын хяналтын шинэ ажлын байрыг 2016 онд бүрэн ашиглалтад оруулж, төрийн хамгаалалтад байх онц чухал объект болсон. 2018 онд Швейцарын хөгжлийн агентлаг, Монголын Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн хүрээнд 36 сая төгрөгийн үнэтэй алт хайлах зуухийг ашиглалтад хүлээн авч лабораторийн техник технологийн шинэчлэлт хийлээ.

**1960-аад онд 7 хоногтоо 2-3 удаа цөөн тооны дээжийг шинжилдэг байсан үнэт металлын сорьц тогтоох лаборатори өнөөдөр 5 химичийн ажлын байртай, жилдээ 6000 гаруй алтны, 5000 гаруй мөнгөний шинжилгээ хийж сорьц тогтоох, 300000-аас багагүй үнэт эдлэлийн сорьцын баталгааны тэмдэг дарах хүчин чадалтай Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн лаборатори болтлоо хөгжсөн байна. Өнөөдөр тус лаборатори орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдаж, шинжилгээний арга, аргачлал нь олон улсын стандартын дагуу хийгдэж, Олон улсын сорьцын хяналтын байгууллагуудын холбооны хамгийн сүүлийн гишүүнээр элсээд байна.**



Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар нь дээр дурдсан түүхэн хөгжлийн үе шатыг туулж өнөөдрийн байдлаар стандартчилал, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын чиглэлээр орон нутгийн 20 салбар хэлтэс, салбарын хэмжээний 350 гаруй ажилтан, албан хаагчид бүхий байгууллага болж өргөжсөн байна.

Тус газар нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ба 2021 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Үйл ажиллагааны стратеги зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т үүрэг хариуцлагыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж Монгол Улсын Шадар сайд, Засгийн газрын танхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. Газар нь салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд хууль тогтоомжийн хүрээнд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдаж зохицуулна.
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын хөгжлийг хурдасгах, олон улсын жишигт хүргэх, Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн экспортыг дэмжсэн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндсэн чиг үүргийнхээ хүрээнд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлыг хамарсан Засгийн газрын зөвлөхийн үүрэг, хариуцлага хүлээнэ.

Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжлийн нэгдмэл байдлыг хангах бодлогоор дэмжих, Монгол Улсын хэмжлийн тогтолцоо, хэмжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхыг нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний болон Бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- Сорьцын хяналтын баталгааг олон улсын түвшинд хүргэх, үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох үйлчилгээг олон улсын стандартын дагуу хийж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;

#### **1.4 Салбарын өмнө тулгамдсан асуудлууд**

Стратеги төлөвлөгөөг оновчтой бодитой боловсруулах үүднээс салбарын өмнө тулгамдсан асуудлыг дараах байдлаар тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлсэн болно. Үүнд:

Нэн их	Их	Дунд
<b>Төрийн захиргаа удирдлагын үйл ажиллагаа</b>		
Салбарын хэмжээнд санхүү эдийн засгийн боломж, материаллаг бааз дутагдалтай	Хүний нөөцийн хомстолд орсон	<p>Үйлчилгээг цахимжуулах ажил хангалтгүй, хэмжил зүй, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд өргөдөл гаргахаас шийдвэр гаргах хугацаа хэтэрхий урт</p> <p>Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ цөөн</p>
<b>Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа</b>		
Техникийн зохицуулалт боловсруулах, батлах ажил зохион байгуулалт сул, удаашралтай байгаагаас аюулгүйн тэмдэг олгох үйл ажиллагаа хангалтгүй	Стандартын шинжлэх ухаан техникийн түвшинг нэмэгдүүлэх, олон улсын түвшинд хүрсэн	Сонирхогч талуудын оролцоо сул
Заавал баталгаажуулалтад хамруулах 644 бүтээгдэхүүний 300 бүтээгдэхүүн тохирлын гэрчилгээнд хамрагддаггүй	стандартын тоо хэмжээ хангалтгүй	
<b>Хэмжил зүйн үйл ажиллагаа</b>		
Эталон тоног төхөөрөмж дутагдалтай тул хэмжил зүйн үйл ажиллагаа доголддог	Эталон лабораторийн орчны нөхцөл хэмжлийн үр дүнд сөргөөр нөлөөлдөг	Эталоны лабораторид ажиллах ажилтны ур чадварыг байнга нэмэгдүүлэх боломж хомс
Өргөдөл хүлээж авахаас шийдвэр гаргах хүртэл хугацаа урт	Хэмжлийн үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрдөггүй	
<b>Үнэт металлын сорьцын хяналтын үйл ажиллагаа</b>		
Тоног төхөөрөмжийг шинэчлэх, шинжилгээний арга аргачлал, үйлчилгээний нэр төрөл цөөн	Эрх зүйн орчин тодорхойгүй	Сургалт, ижил төстэй гадны байгууллагад дадлагажих боломж хомс

### **1.5 Стратеги боловсруулах хэрэгцээ, шаардлага**

2018-2019 онуудад тус салбарын эрх зүйн орчин шинэчлэгдэж Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их хурлаас баталсан бол 2020 онд Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050” батлагдан гарсан.

Стандарт, хэмжил зүйн газрын хувьд дээрх бодлогын баримт бичигт нийцүүлэн стратегийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, алсын хараа, эрхэм зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зайлшгүй шаардлага үүсч байна. Тухайлбал Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 270 дугаар тушаалаар Үндэсний итгэмжлэлийн төвийн дүрмийг баталж бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулах бодлого баримтлах болсон, өөрөөр хэлбэл тохирлын үнэлгээний итгэмжлэлийн чиг үүргийг Стандарт, хэмжил зүйн газар хэрэгжүүлэхээргүй болсон байна. Стратегийн зорилтыг тусгасан боловч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлалын дагуу зорилт нь үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц байх, арга хэмжээнүүд нь зорилтдоо чиглэсэн байх, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц (SMART) байх, тоон мэдээлэл нь чанарын үзүүлэлтээр баталгаажсан байх зэрэг үндсэн шаардлагууд хангагдахгүй байна гэж үзэж байна.

### **ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ**

Стандарт, хэмжил зүйн газар нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Засгийн газрын тохируулагч агентлаг юм. Тус байгууллага нь Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 32 дугаар тушаалаар баталсан “Үйл ажиллагааны стратеги зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т зааснаар дараах үндсэн нэгжүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Захиргаа, удирдлагын газар
- Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
- Санхүүгийн хэлтэс
- Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар
- Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар
- Сорьцын хяналтын газар
- Хэмжил зүйн бодлогын газар
  - o Хэмжил зүйн хүрээлэн
  - o Шалгалт тохируулгын хэлтэс
- Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газар
- Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын төв

Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг дараах хууль тогтоомж (Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Олон улсын гэрээ конвенцоор олгосон чиг үүрэг)-оор тодорхойлсон байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1

<b>Монгол Улсын хуулиуд</b>		Огноо	Дугаар
1	Авлигын эсрэг хууль	2006.07.06	
2	Ашигт малтмалын тухай хууль	2006.07.08	
3	Байгууллагын нууцын тухай хууль	1995.05.16	
4	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль	2004.04.15	
5	Захиргааны ерөнхий хууль	2015.06.19	
6	Зөрчлийн тухай хууль	2017.05.11	
7	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	1995.04.17	
8	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль	1993.05.06	
9	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	2012.01.19	
10	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль	2017.12.21	
11	Төрийн албаны тухай хууль	2017.12.07	
12	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	2005.12.01	
13	Төсвийн тухай хууль	2011.12.23	
14	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	2020.05.07	
15	Хөдөлмөрийн тухай хууль	2021.07.02	
16	Хууль тогтоомжийн тухай хууль	2015.05.29	
17	Хэмжил зүйн тухай хууль	2019.05.09	
18	Хэмжил зүйн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль	2019.05.09	
19	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль	2003.12.26	
20	Шилэн дансны тухай хууль	2014.07.01	
21	Эрдэнэсийн сангийн тухай хууль	1994.11.17	
<b>Монгол Улсын Их Хурлын тогтоол</b>			
1	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай	2020.05.13	52
2	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай	2020.08.28	23
3	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	2020.08.28	24
4	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам	2019	21
5	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	2017	87

Дээрх хууль тогтоомж, тогтоол шийдвэрт хамааралтай Стандарт, хэмжил

зүйн газрын ерөнхий, болон үндсэн чиг үүргийг үйл ажиллагааны чиглэлээр дараах байдлаар ангилж байна. Үүнд:

1. Ерөнхий чиг үүрэг: Стандартчилал, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлого, зохицуулалт
  - 1.1. Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлого, стратеги төлөвлөх үйл ажиллагаа
  - 1.2. Хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа
  - 1.3. Стандартчилал, техникийн зохицуулалтын үйл ажиллагаа
  - 1.4. Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа
  - 1.5. Хэмжил зүйн бодлого, үйл ажиллагаа
  - 1.6. Үнэт металл, эрдэнийн чулуу, сорьцын хяналтын үйл ажиллагаа

Хүснэгт 2.

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		21
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	5
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	16
<b>Ерөнхий чиг үүрэг-1:</b> Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлого, зохицуулалт		
<b>Үндсэн чиг үүрэг</b>	<b>Дэд чиг үүрэг</b>	<b>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</b>
1. Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлого, стратеги төлөвлөх	1.1. Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх	Стандарт, хэмжил зүйн газрын үндсэн нэгжүүд Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд
	1.2. Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх	
	1.3. Удирдлагад мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	
	1.4. Хууль эрх зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх	
	1.5. Хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах	
	1.6. Салбарын богино ба урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах.	
2. Хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээ	2.1. Хууль тогтоомж, дээд байгууллагын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүн өгөөжийг тодорхойлох, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах.	Стандарт, хэмжил зүйн газрын үндсэн нэгжүүд Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсүүд
	2.2. Байгууллагын үйл ажиллагааны хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх	

<p>3. Стандартчилал, техникийн зохицуулалтын үйл ажиллагаа</p>	<p>3.1. Техникийн зохицуулалтыг батлах, мэдээллийн санд хүлээлгэн өгөх, нийтэд мэдээлэх</p> <p>3.2. Гадаад улс орны стандартыг түр хэрэглэх хүсэлтийг хүлээн авах бүртгэх</p> <p>3.3. Олон улс, Бүс нутгийн, хөрш орны стандартчиллын байгууллагатай хамтран ажиллах</p> <p>3.4. Олон улс, гадаад орны стандартын талаарх холбогдох лавлагаа, мэдээллээр хангах</p> <p>3.5. Олон улсын стандартчиллын байгууллагын техникийн хороодын үйл ажиллагаанд оролцох</p> <p>3.6. Стандартчиллын техникийн хороог шинээр болон шинэчлэн байгуулах</p> <p>3.7. Стандартчиллын тогтолцооны баримт бичиг боловсруулах</p> <p>3.8. Стандартчиллын хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах</p> <p>3.9. Стандартын төсөлд техникийн түвшинд үнэлгээ өгөх, шүүлт хийх, стандарт батлах</p> <p>3.10. Сургалт зохион байгуулах</p> <p>3.11. Техникийн зохицуулалт боловсруулах байгууллагад дэмжлэг үзүүлэх</p> <p>3.12. Техникийн зохицуулалтын баримт бичигт шинжилгээ хийх, эрэмбэлэх</p> <p>3.13. Техникийн зохицуулалтын төсөлд шүүлт хийх</p> <p>3.14. Тохирлын үнэлгээний талаар бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах</p> <p>3.15. Үндэсний стандартын үзүүлэлт, шаардлагыг олон улс, бүс нутгийн стандартын шаардлагад нийцүүлэх</p>	<p>Яамдууд Техникийн хороод</p>
<p>4. Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа</p>	<p>4.1. Аюулгүйн тэмдэг хэрэглэх бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ явуулж, гэрчилгээжүүлэх</p> <p>4.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх</p> <p>4.3. Олон Улсын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн байгууллагад тохирлын үнэлгээ явуулах</p> <p>4.4. Тохирлын баталгаатай</p>	<p>Баталгаажуулалтын зөвлөл.</p> <p>Орон тооны бус шинжээч, аудиторууд</p>



	бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх	
5. Хэмжил зүйн бодлого, үйл ажиллагаа	5.1.Хэмжил зүйн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Хэмжил зүйн зөвлөл
	5.2.Хэмжлийн улсын, анхдагч болон ажлын эталоныг шинээр, шинэчлэн бий болгох, сайжруулах, судалгаа шинжилгээ хийх	
	5.3.Хэмжил зүйн чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, бүртгэх	
	5.4.Хэмжих хэрэгслийн загварыг турших батлах	
	5.5.Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, бүртгэх ажлыг зохион байгуулах	
	5.6.Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад эрх олгох ажлыг зохион байгуулах	
	5.7.Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх ажлыг зохион байгуулах	
	5.8.Хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах	
6. Үнэт металл, эрдэнийн чулуу, сорьцын хяналтын үйл ажиллагаа	6.1.Сорьцын лабораторийг бэхжүүлэх	-

#### **ГУРАВ. АЛСЫН ХАРАА**

Амьдралын чанарыг сайжруулна.

#### **ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хэмжил зүй, стандартчилал, сорьцын хяналт, тохирлын үнэлгээний бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлж, чанартай төрийн үйлчилгээг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөд тулгуурлан хэрэглэгчдээ хүргэхэд оршино.

#### **ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ**

Стандарт, хэмжил зүйн газар нь чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бодитой тодорхойлох, зорилгоор гадаад болон дотоод орчны шинжилгээг хийсэн ба дараах хүчин зүйлс нөлөөлнө гэж үзлээ. Үүнд:

- Гадаад орчин:

- Улс төр,
- Эдийн засаг, нийгэм соёл, технологи
- Хууль, эрх зүй
- Дотоод орчин
  - Бүтэц, зохион байгуулалт, байгууллагын соёл
  - Нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл)
  - Үйл явц

### 5.1 Гадаад орчны шинжилгээ

Монгол Улсын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны хуульд төрийн алба мэргэшсэн, тогтвортой, шатлан дэвшүүлдэг байх үзэл баримтлал туссан хэдий ч 2000 оноос хойших 6 удаагийн сонгуулийн мөчлөгт Стандарт, хэмжил зүйн газрыг 5 дарга удирдсан байна. Түүнчлэн үйл ажиллагааны стратеги зохион байгуулалт бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр 2012-2016 оны хооронд 4 удаа шинэчлэгдсэн бөгөөд Стандарт, хэмжил зүйн газрын ерөнхий чиг үүрэг болон үндсэн нэгжүүдийн чиг үүрэгт төдийлөн өөрчлөлт ороогүй боловч тухай бүр ажилтан, албан хаагчид, нэгжийн дарга нарын шилжилт хөдөлгөөн хийгдсэн нь үйл ажиллагаанд нөлөөлж байлаа. Өөрөөр хэлбэл тус салбарын үйл ажиллагаанд улс төрийн орчны нөлөөлөл их биш боловч тодорхой хувиар байсаар ирсэн гэж үзэж болохоор байна.

Эдийн засгийн орчны хувьд тус салбараар үйлчлүүлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн тоог үйлчилгээ авсан чиг үүрэг тус бүрээр гаргалаа.

№	Чиг үүрэг	2016	2017	2018	2019	2020
1	Стандартчилал, техникийн зохицуулалтын үйл ажиллагаа	1493	1426	1392	1945	1959
2	Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа	751	934	1252	1554	1396
3	Хэмжил зүйн бодлого, үйл ажиллагаа	2848	3214	3834	3881	3737
4	Үнэт металл, эрдэнийн чулуу, сорьцын хяналтын үйл ажиллагаа	4613	4488	4649	4650	3020
5	Бусад	224	165	428	379	443
	<b>ДҮН</b>	<b>9,929</b>	<b>10,227</b>	<b>11,555</b>	<b>12,409</b>	<b>10,555</b>

Тус газраас иргэн аж ахуйн нэгжийн авсан үйлчилгээний төрөл, тоо хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Чиг үүрэг	2016	2017	2018	2019	2020
1	Стандартын үйлчилгээ	2,170	2,684	2,914	3,252	3,285
2	Тохирлын үнэлгээний үйлчилгээ	4,945	5,534	5,946	6,678	6,732
3	Хэмжил зүйн ажил үйлчилгээ	74,846	82,706	67,810	86,114	74,164
4	Үнэт металл, эрдэнийн чулуу, сорьцын хяналтын	4,613	4,488	4,649	4,720	3,103

	үйлчилгээ					
	Сургалтын үйлчилгээ	331	383	321	439	466
5	Бусад	230	179	463	418	478
	<b>ДҮН</b>	<b>87,135</b>	<b>95,974</b>	<b>82,103</b>	<b>101,621</b>	<b>88,228</b>

Аймгуудын Стандарт, хэмжил зүйн хэлтсээс иргэн аж ахуйн нэгжийн авсан үйлчилгээний төрлийг дараах хүснэгтэд үзүүлэв.

№	Чиг үүрэг	2016	2017	2018	2019	2020
1	Стандартын үйлчилгээ	978	1,606	1,831	1,722	1,770
2	Тохирлын үнэлгээний үйлчилгээ	4,194	4,600	4,694	5,124	5,336
3	Хэмжил зүйн ажил үйлчилгээ	74,014	81,509	65,994	84,252	72,447
4	Үнэт металл, эрдэнийн чулуу, сорьцын хяналтын үйлчилгээ	-	-	-	70	83
5	Бусад	6	14	35	39	35
	<b>ДҮН</b>	<b>79,192</b>	<b>87,729</b>	<b>72,554</b>	<b>91,207</b>	<b>79,671</b>

Дээрх үзүүлэлтээс харахад Стандарт, хэмжил зүйн салбараар үйлчлүүлдэг иргэд аж ахуйн нэгжийн тоо сүүлийн 5 жилд харьцангуй тогтвортой буюу 12 орчим мянга байгаа бол үзүүлж байгаа үйлчилгээний тоо 160-190 мянган хооронд хэлбэлзэж байна.

2020 оны хувьд дэлхий нийтийг цочроосон цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засгийн голлох салбаруудын үйл ажиллагаа тодорхой түвшинд зогссон боловч тус салбарын хувьд үйлчилгээ авдаг иргэд, үйлчлүүлэгчдийн болон үйлчилгээний тоонд төдийлөн өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын хэмжээнд 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 6630 стандарт мөрдөгдөж байгаагаас 40 орчим хувь нь олон улсын стандарт байна. Хэдийгээр олон улсын стандартыг үндэсний стандарт болгох ажил хийгдэж байгаа боловч мега төсөл (нефть боловсруулах үйлдвэр, уул уурхай)-үүдэд мөрдөж байгаа стандартууд нь технологийн хувьд хоцрогдсон эсвэл үндэсний стандарт огт байхгүй байна. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүнийг худалдан авах орны стандарттай ижилтгэх ажил хангалтгүй байгаагаас дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдаанд техникийн саад тотгор тодорхой түвшинд байсаар байна. Өөрөөр хэлбэл сүүлийн жилүүдэд олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-д гишүүнчлэлтэй байгаа давуу байдлаа ашиглан экспортын бүтээгдэхүүний стандартыг олон улсын стандартаар батлуулах ажил хангалтгүй хийж байна гэж үзлээ.

Хууль, эрх зүйн орчны хувьд 2018-2019 онуудад Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийг олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж баталсан ба хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, дүрэм, журмууд батлагдсанаар хангалттай бүрдсэн байна. Өөрөөр хэлбэл ирэх 5-10 жилд хууль, эрх зүйн орчин харьцангуй

тогтвортой байх төлөвтэй байна.

## **5.2 Дотоод орчны шинжилгээ**

Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны стратеги зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт үндсэн нэгжүүдийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү эдийн засгийн төлөвлөлтийн үр өгөөжийг дээшлүүлэх, зохицуулалтыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутаг, гадаад орны хүрээнд өргөжүүлэх;
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах, бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх;
- Стандартчиллын хөтөлбөр, төсөл боловсруулах, техникийн зохицуулалтыг олон улсын жишгээр бий болгоход дэмжлэг үзүүлэх, төсөлд шүүлт хийх, дүрэм, журам, заавар, удирдамж арга зүйгээр хангах;
- Хэмжлийн нэгжийн олон улсын системд тулгуурласан үндэсний эталоны тогтолцоог хөгжүүлэх, нарийвчлалыг олон улсын түвшинд ойртуулах, үндэсний эталоноос нэгж дамжуулах тогтолцоог сайжруулан бэхжүүлэх;
- Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажлын чанарыг зах зээлд хүртээмжтэйгээр олон улсын түвшинд хүргэх;
- Сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх;
- Олон улсын гэрээ, хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт, холбогдох норматив-техникийн баримт бичгээс бүрдсэн үндэсний мэдээллийн санг хөгжүүлэх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;
- Баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх, баталгаажуулалтын ажлын чанарыг олон улсын түвшинд хүргэх;

2021 оны 09 дүгээр сарын байдлаар батлагдсан орон тооны дээд хязгаар 115 байна. Тоо баримтаас харахад Стандарт, хэмжил зүйн газар нь 2012 онд 136 ажилтан албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан орон тооны дээд хязгаар 115 болж буурсан байна. (Хүснэгт 3)

Жилээс жилд нийгэм, эдийн засгийн хөгжилд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, үнэт металлын сорьцын хяналтын гүйцэтгэх үүрэг, ажилтан,

албан хаагчдын ажлын ачаалал нэмэгдэж байгаа ч орон тоо буурч байгаа нь Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар буурах нэг нөхцөл болж байна.

Хүснэгт 3

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Дарга, дэд дарга	1	2	1	2	3	3	3	3	2
Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж	26	24	25	18	13	15	15	16	18
Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж	8	8	8	7	8	7	8	7	7
Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын асуудал хариуцсан нэгж	14	12	15	12	12	12	12	11	11
Сорьцын хяналтын асуудал хариуцсан нэгж	17	16	15	14	14	14	14	15	14
Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж	14	14	14	8	9	9	9	10	9
Хэмжил зүйн хүрээлэн	22	23	25	22	18	18	18	18	20
Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж	23	25	26	23	21	21	21	21	21
Шалгалт тохируулгын асуудал хариуцсан нэгж	-	-	-	-	8	8	8	8	10
Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын асуудал хариуцсан нэгж	8	8	8	8	9	7	7	6	7
<b>Нийт</b>	<b>133</b>	<b>132</b>	<b>137</b>	<b>114</b>	<b>115</b>	<b>114</b>	<b>115</b>	<b>115</b>	<b>119</b>
<i>Итгэмжлэлийн газар*</i>	12	13	8	9	8	9	8	8	7
Бүгд	145	145	145	123	123	123	123	123	126

Одоо байгаа орон тооны хязгаарт багтаан зохион байгуулалтын арга хэмжээг авсан тохиолдолд дараах үр дүн гарна гэж үзсэн.

- Ажлын ачаалал өчүүхэн бага хэмжээгээр өөрчлөгдөх бөгөөд Стандарт, хэмжил зүйн газрын урсгал зардал болон, орлогод ямар нэгэн өөрчлөлт орохгүй
- Хэмжих хэрэгслийн болон бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаанд ямар нэгэн чанарын өөрчлөлт орохгүй
- Өнөөгийн байдлаар баталгаажуулалтад бүрэн хамруулж чадахгүй

байгаа хэмжих, хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаанд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй

- Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зарим арга хэмжээ тасалдах эрсдэлтэй

Харин одоо байгаа орон тоог 145 болгон нэмэгдүүлсэн тохиолдолд дараах үр нөлөө үзүүлнэ гэж үзсэн байна. Үүнд:

- Шинээр орон тоо нэмэгдүүлсэн тохиолдолд урсгал зардал 556 орчим сая төгрөгөөр нэмэгдэнэ.
- Орлого 30 орчим хувь буюу суурь түвшинд 3.3 орчим тэрбум төгрөг байгаагаас 900 орчим сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой.
- Хэмжих хэрэгслийн болон бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаа чанарын хувьд сайжирч хэрэглэгчийн гомдол багасна.
- Өнөөгийн байдлаар баталгаажуулалтад бүрэн хамруулж чадахгүй байгаа хэмжих, хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагааг бүрэн хамруулах нөхцөл бүрдэнэ.
- Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрэн биелэх нөхцөл бүрдэнэ.

Ажилтан албан хаагчдын боловсролын түвшин:

Хүснэгт 4

№	Их, дээд сургуулийн нэрс	Суурь түвшин	Боловсон хүчний нарийвчилсан тоо			
		2016	2017	2018	2019	2020
1.	Дотоодын их, дээд сургууль	88	91	90	88	89
2.	Гадаадын их, дээд сургууль	38	39	40	34	30
3.	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв.... гэх мэт.	13	10	10	10	11

Харин орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн боловсон хүчний судалгааг дараах байдлаар гаргалаа. Үүнд:

№	Үндсэн чиг үүрэг буюу Дэд салбар	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он	
		Дээд боловсрол	Мэргэжилтэй ажилтан	Дээд боловсрол	Мэргэжилтэй ажилтан	Дээд боловсрол	Мэргэжилтэй ажилтан	Дээд боловсрол	Мэргэжилтэй ажилтан	Дээд боловсрол	Мэргэжилтэй ажилтан
1	Хэмжил зүй	59	4	61	4	61	5	61	4	64	3
2	Стандарт	19	1	18	1	17	1	18	1	19	1
3	Баталгаажуулалт	33	1	34	1	35	1	36	1	36	1
4	Сорьцын хяналт	17	1	18	1	21	1	24	1	24	1
5	Нийтлэг чиг үүрэг	42	58	40	55	42	55	40	55	41	53



/нягтлан, жижүүр, үйлчлэгч, жолооч .... гэх мэт/											
<b>Дүн</b>	<b>170</b>	<b>65</b>	<b>171</b>	<b>62</b>	<b>176</b>	<b>63</b>	<b>179</b>	<b>62</b>	<b>184</b>	<b>59</b>	
<b>Нийт албан хаагчид</b>	<b>235</b>		<b>233</b>		<b>239</b>		<b>241</b>		<b>243</b>		

Бусад нөөцийн хувьд Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагаанд төдийлөн сөргөөр нөлөөлөхгүй боловч урт хугацаандаа хөрөнгө оруулалтыг жил бүрийн төсөвт тусгах нь зүйтэй байна.

Мэдээллийн болон технологийн нөөц:

№	Мэдээллийн системийн нэр	Хэрэглэгч байгууллага	Бүтээсэн он	Хэрэглэгчийн тоо
<b>Нэг. Төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах мэдээллийн системүүд</b>				
1.	Мэдээллийн систем №1.1 able cloud	СХЗГ	2014	100
2.	Мэдээллийн систем №1.2 Хэмжих хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан	СХЗГ	2020	125
3	Мэдээллийн систем №1.3 Баталгаажуулсан бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан	СХЗГ	2020	3
4	Isoluiton			
<b>Хоёр Төрийн үйлчилгээг сайжруулах мэдээллийн системүүд</b>				
5	Мэдээллийн систем №2 1 www.estandart.gov.mn		2020	200-500
6	Мэдээллийн систем №2.2 www.masm.gov.mn		2020	200-500

Тоног төхөөрөмж болон бусад нөөц:

№	Нөөцийн нэр	Суурь түвшин 2016 он		Нөөц ашиглалт			
		Хэмжих нэгж	Нөөцийн хэмжээ	2017	2018	2019	2020
<b>Стандарт хэмжил зүйн газар</b>							
1	Суурин компьютер	ширхэг	127	134	146	147	148
2	Зөөврийн компьютер	ширхэг	44	42	41	41	61
3	Принтер	ширхэг	45	47	51	57	64
4	Хувилах төхөөрөмж	ширхэг	5	5	5	5	5
5	Эталон тоног төхөөрөмж	ширхэг	150	155	155	155	155
6	Тээврийн хэрэгсэл	ширхэг	5	5	5	6	6

Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс							
1	Суурин компьютер	ширхэг	102	102	103	105	98
2	Зөөврийн компьютер	ширхэг	57	60	62	67	64
3	Принтер	ширхэг	85	85	87	91	88
4	Скайнер	ширхэг	16	16	17	18	19
5	Эталон тоног төхөөрөмж	ширхэг	396	453	472	557	576
6	Тээврийн хэрэгсэл	ширхэг	19	18	18	19	17
7	Тавилга эд хогшил	ширхэг	1069	1074	1072	1015	1073
8	Барилга /граж/	ширхэг	23	23	23	23	23
9	Газар		12	12	12	15	16

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж орон нутгийн хөрөнгөөр шийдүүлсэн үйл ажиллагааны мөнгөн дүн/мян.төг/

№	Хэлтсийн нэр	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020	Нийт дүн
1	Архангай		10,000	25,000		40,000	<b>75,000</b>
2	Баян-Өлгий			320	500		<b>820</b>
3	Баянхонгор						-
4	Булган	11,950	1,180	47,860	3,532.7	3,500	<b>68,022.7</b>
5	Говь-Алтай				4,500		<b>4,500</b>
6	Дархан-Уул						-
7	Дорноговь		6,000			20,000	<b>26,000</b>
8	Дорнод	9,200			18,000		<b>27,200</b>
9	Дундговь			26,077.5			<b>26,077.5</b>
10	Завхан	1,400	10,440	-	3,000	40,000	<b>54,840</b>
11	Орхон		10,000	46,740			<b>56,740</b>
12	Өвөрхангай	3,500	3,000	17,000			<b>23,500</b>
13	Өмнөговь	7,500	9,800			9,100	<b>26,400</b>
14	Сүхбаатар					34,000	<b>34,000</b>
15	Сэлэнгэ	6,500			9,500	5,500	<b>21,500</b>
16	Төв			14,800		30,000	<b>44,800</b>
17	Увс		2,250				<b>2,250</b>
18	Ховд						-
19	Хөвсгөл					60,230	<b>60,230</b>
20	Хэнтий			2,000	5,000	10,000	<b>17,000</b>

Стандарт хэмжил зүйн газар нь улсын төсвөөс санхүүждэг ба 2016-2020 онд Монгол Улсын төсөвт Стандарт, хэмжил зүйн зардлыг дараах байдлаар тусгасан байна.

№	Чиг үүрэг	2016	2017	2018	2019	2020
1	Стандарт, хэмжил зүйн газрын зардал (мянган төгрөгөөр)	4922893.2	5105288.5	5847010.3	6187684.0	8286830.2
2	Хөрөнгө оруулалт (мянган төгрөгөөр)	-	-	346000.0	780000.0	400000.0

2008 онд улсын төсөвт 800 орчим сая төгрөгийг төвлөрүүлж байсан бол 2018, 2019 онд тус бүр 4.3 тэрбум төгрөг, 2020 онд 6.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлсэн нийт орлогын 58 хувийг хэмжил зүйн бодлого, үйл ажиллагааны орлого эзэлсэн байна.

Хүснэгт 5

№	Чиг үүрэг	2016	2017	2018	2019	2020
1	Стандартчилал, техникийн зохицуулалтын үйл ажиллагаа	117,964.7	164,551.1	182,556.2	210,639.6	279,835.3
2	Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа	343,321.2	397,579.4	505,895.7	678,310.2	864,374.8
3	Хэмжил зүйн бодлого, үйл ажиллагаа	2,169,340.8	2,172,455.6	2,414,529.1	2,500,334.1	2,655,608.8
4	Үнэт металл, эрдэнийн чулуу, сорьцын хяналтын үйл ажиллагаа	1,113,584.4	121,652.5	1,285,532.5	945,054.4	2,965,108.7
	<b>ДҮН</b>	<b>3,744,211.1</b>	<b>2,856,238.6</b>	<b>4,388,513.5</b>	<b>4,334,338.3</b>	<b>6,764,924.6</b>

2020 онд Стандарт, хэмжил зүйн газар нь 6.76 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 8.28 тэрбум төгрөгийн зардал гаргасан байна. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны орлого нь зардлын 81.6 хувийг бүрдүүлж байна. Цаашид заавал баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгсэл болон бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар орлого нь зардлаа нөхдөг тогтолцоо руу шилжих нь зүйтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын орчны шинжилгээг давуу байдал, сул тал, боломж, эрсдэл(SWOT) гэсэн үндсэн шалгуураар хийсэн бөгөөд сонирхогч талуудын саналыг тусгасан.

Стандарт, хэмжил зүйн газрын давуу тал:	Стандарт, хэмжил зүйн газрын сул тал:
<ul style="list-style-type: none"> <li>- Стандартчилал, техникийн зохицуулалт, хэмжилзүй болон тохирлын үнэлгээний үйл ажиллагааг зохицуулсан хуультай;</li> <li>- Засгийн газрын дэмжлэгтэй</li> <li>- Бусад төрийн захиргааны болон төрийн өмчит байгууллагатай чиг үүргийн давхардал байхгүй</li> <li>- Монгол Улсад стандартчилал, хэмжилзүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын чиглэлээр нэг байгууллага үйл ажиллагаа явуулдаг ба 20 аймагт салбар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газар, яамдын түвшинд стандартчилал, хэмжилзүй, тохирлын үнэлгээний талаарх ойлголт хангалтгүй;</li> <li>- Бодлого боловсруулахад оролцох сонирхогч талуудын оролцоо дутагдалтай;</li> <li>- Ажилтны тоо цөөн, ажлын ачаалал их тул үйл ажиллагаанд хяналт тавихад хүндрэл үүсдэг;</li> <li>- Үйл ажиллагааны талаарх мэдээлэл хомс, мэдээллийн сан хангалтгүй, анализ болон статистик</li> </ul>

<p>хэлтэстэй;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Стандартчилал, хэмжилзүй, сорьцын хяналт, тохирлын үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон бүс нутгийн байгууллагын гишүүн /ISO, IEC, IAAO, OIML, CIPM, CGPM/</li> <li>- Хэмжил зүйн улсын эталоны лабораториуд, Сорьцын хяналтын лаборатори нь тогтвортой үйл ажиллагаа явуулдаг;</li> <li>- Тохируулагч агентлаг тул хууль тогтоомж, стандартыг албадан сахиулах чиг үүргийг хэрэгжүүлдэг;</li> <li>- Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001 стандарт нэвтрүүлсэн;</li> <li>- Чадварлаг ажилтнуудтай бөгөөд дээд удирдлага туршлагатай;</li> <li>- Ашгийн төлөө бус, Засгийн газрын байгууллага;</li> <li>- Хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ танигдсан 98 жилийн түүхтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг</li> </ul>	<p>сул, байгууллагын дотоод харилцаа холбоо хангалтгүй;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тоног төхөөрөмж, эталоны хангамж, хөрөнгө оруулалт хангалтгүй;</li> <li>- Мэдээллийн технологийн систем (программ хангамж) дутагдалтай.</li> </ul>
<p align="center"><b>Стандарт, хэмжил зүйн газрын боломж:</b></p>	<p align="center"><b>Стандарт, хэмжил зүйн газрын эрсдэл:</b></p>
<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага тул хууль эрх зүй, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийг шаардлагатай тохиолдолд шинэчлэх;</li> <li>- Монгол Улсын Шадар сайд Аймгийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч бодлого, үйл ажиллагааг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх;</li> <li>- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэг ба давсан болон нэмэлт орлогыг тодорхой хувийг захиран зарцуулах эрхтэй;</li> <li>- Засгийн газрын хэмжээнд гадаад орчны бүтцийн аливаа өөрчлөлтөд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын эдийн засгийн тогтворгүй байдал нь тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай;</li> <li>- Хувийн хэвшлийн байгууллагуудын хууль бус үйл ажиллагаа, өрсөлдөөн</li> <li>- Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэн бэлтгэж буй сургууль байхгүй,</li> <li>- Үйл ажиллагааг хэрэгжүүлж буй чиглэлээр хангалттай хүний нөөц байхгүй тул нөлөөлөлд орох магадлалтай,</li> <li>- Шаардлагатай тоног төхөөрөмж</li> </ul>

<p>орох магадлал бага;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эталон лабораториудын Олон улсын харьцуулалтад тогтмол оролцдог;</li> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжил;</li> <li>- Сүүлийн 5 жилийн статистик мэдээнээс үзвэл хэрэглэгч үйлчлүүлэгчдийн тоо өсөх хандлагатай;</li> <li>- Ажилтнууд нь олон улсын төрөл бүрийн сургалтад оролцох, шинэ мэдлэг, мэдээлэл авах, сурч боловсрох өргөн боломжтой.</li> <li>- Олон улсаас хэрэгжүүлэх донор төсөл хөтөлбөрт хамрагдах, хүний нөөцийг чадавхжуулах</li> <li>- Үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх</li> <li>- Орлогыг нэмэгдүүлэх</li> </ul>	<p>байхгүй, хувийн хэвшлийн зарим байгууллагад үйл ажиллагаа явуулдаг тул нөлөөлөл өртөх, ашиг сонирхлын зөрчил гаргаж болзошгүй</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цалин хөлс бага тул мэргэшсэн албан хаагчдыг алдах магадлалтай</li> </ul>
--	---

**SWOT** шинжилгээний дүнг үндэслэн **SWOT** синтезийн аргаар давуу талаа ашиглан бэрхшээлийг даван туулах, боломжоо ашиглан сул талаа арилгах арга замаа тодорхойлсны үндсэн дээр зорилго, стратегийн зорилтыг тодорхойллоо.

<p><b>Давуу талаа ашиглах боломжоо тодорхойлох (SO шийдвэр)</b></p>	<p><b>Боломжоо ашиглан сул талаа арилгах (OW шийдвэр)</b></p>
<ul style="list-style-type: none"> <li>- СХЗГ нь үйл ажиллагаагаа дэмжин хамтарч ажиллах нийгмийн бүлгүүдийг тодорхойлох;</li> <li>- Гадаад, дотоод туршлагад тулгуурлан бодлого боловсруулах;</li> <li>- Засгийн газрын зүгээс авах дэмжлэгийг тодорхойлох;</li> <li>- Гадаад орчны байдал, мэдээлэл авах боломж, Засгийн газрын дэмжлэгийг ашиглан боловсон хүчнээ сургах дадлагажуулах;</li> <li>- Багаар ажиллах боломжийг ашиглан эвсэг, гар нийлсэн хамт олныг бүрдүүлэх;</li> <li>- Гадаад орон олон улсын байгууллагын тусламжийг , нэмэлт орлогодоо тулгуурлан эталон төхөөрөмжийн боломж, чадавхаа нэмэгдүүлэх;</li> <li>- Компьютер, техник хэрэгслийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажилтнууд туршлага, мэдлэгээ нэмэгдүүлэн өөрийгөө дайчлах;</li> <li>- Гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, эрхзүйн орчныг харьцуулан судлах;</li> <li>- Зах зээлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан, Засгийн газрын дэмжлэгт үндэслэн орон нутагт дахь салбар нэгжийн чадавхыг нэмэгдүүлэх;</li> <li>- Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн чиг үүргийг нарийвчлан тогтоох, уялдааг хангах;</li> <li>- Мэдээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох;</li> <li>- Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн үйл ажиллагааны процессоо тодорхойлох.</li> <li>- Батлагдсан хууль тогтоомж,</li> </ul>

<p>боломжийг ашиглан интернетэд холбогдох, мэдээллийг түргэн авч үйл ажиллагаандаа ажил хэрэг болгох.</p>	<p>Засгийн газрын дэмжлэгийн хүрээнд яамд болон төрийн байгууллагуудад Стандарт, хэмжил зүйн талаарх ач холбогдол, ойлголтыг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Стандарт, хэмжил зүйн талаарх ач холбогдол, Олон улсын гишүүнчлэл, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх замаар сонирхогч талын оролцоог нэмэгдүүлэх</li> <li>- өөрийн орлогыг нэмэгдүүлэн төрийн үйлчилгээний чанар хүртээмж, нийгэм эдийн засгийн байдалтай уялдуулан орон тоог нэмэгдүүлэх</li> <li>- мэдээлэл технологийг хөгжүүлэх замаар мэдээллийн сан, бааз суурийг бий болгох</li> <li>- Олон Улсын гишүүн байгууллагын дэмжлэг, нэмэлт орлогоо нэмэгдүүлэх замаар тоног төхөөрөмж, эталоны хангамж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</li> </ul>
<p><b>Давуу талаа ашиглан бэршээлийг даван туулах (ST шийдвэр)</b></p>	<p><b>Сул тал, бэрхшээлийг арилгах (TW шийдвэр)</b></p>
<ul style="list-style-type: none"> <li>- Орон тоог нэмэгдүүлэх</li> <li>- Эталон, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж байгууллагаас тоног төхөөрөмжийн хараат байдлыг үгүй болгож нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг албадлагын аргаар хангуулах, хяналтыг нэмэгдүүлж хууль бус үйл ажиллагааг хязгаарлах;</li> <li>- Олон улсын гишүүн байгууллага, Засгийн газрын тэтгэлэг, дэмжлэгээр сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэн албан хаагчдыг мэргэшүүлэх;</li> </ul>

Дээрх дүн шинжилгээнээс харахад Монгол Улсад стандартчилал, хэмжил зүй, сорьцын хяналт, тохирлын үнэлгээний тогтолцоо тодорхой хэмжээнд бүрэлдэн тогтсон боловч стратегийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой, үр дүнд чиглэсэн байдлаар шинэчлэн боловсруулахгүй бол үйл ажиллагаа доголдох эрсдэл бий болсон байна. Одоо нэгэнт бий болсон давуу тал, боломжоо ашиглан цаашид хөгжлийн шинэ түвшинд гарах зайлшгүй шаардлагатай юм. Үүний тулд дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Стандарт, хэмжил зүйн салбарын стратеги төлөвлөгөөг нэн яаралтай баталж хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах;
- Нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх,



шаардлагатай тохиолдолд олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамрагдах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

- Стандартчилал, хэмжилзүй, тохирлын үнэлгээний бодлогын асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн урт хугацаанд төлөвлөх;
- Стратегийн зорилгыг хүрч болохуйц, хэмжигдэхүйц байдлаар, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар тодорхойлох;

### **ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО**

Стандарт, хэмжил зүйн газар нь мандатын болон орчны шинжилгээнд тулгуурлан стратегийн зорилгоо дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дээрх стратегийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Стратегийн зорилт 1: Стандарт, хэмжил зүйн салбарын орлогыг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт 2: Стандарт, хэмжил зүйн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт 3: Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж буй үйлчилгээг цахимжуулна.

Стратегийн зорилт 4: Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Стратегийн зорилт 5: Үндэсний стандартад олон улсын стандартын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт 6: Техникийн зохицуулалт боловсруулахад төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

Стратегийн зорилт 7: Хэмжил зүйн салбарт зайлшгүй шаардлагатай улсын болон ажлын эталон бий болгоно.

Стратегийн зорилт 8: Эталоны шалгалт тохируулга, хэмжлийн чадавхиа үнэлүүлж олон улсад хүлээн зөвшөөрүүлнэ.

Стратегийн зорилт 9: Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт 10: Үнэт металлын сорьцын хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.

Стратегийн зорилт 11: Стандарт, хэмжил зүйн салбарын мэргэжилтэн бэлтгэх, чадавхжуулах тогтолцоог бүрдүүлнэ.

**ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН.**

Стратегийн зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2020 он)	Зорилтот түвшин (2024 он)
Стратегийн зорилт 1: Стандарт, хэмжил зүйн салбарын орлогыг нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсөв	8.3 тэрбум	12 тэрбум
Стратегийн зорилт 2: Стандарт хэмжил зүйн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Хөрөнгө оруулалт, төгрөг		12 тэрбум
Стратегийн зорилт 3: Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулна.	Цахим үйлчилгээ, хувь	20	100
Стратегийн зорилт 4: Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Хамтран зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	6
Стратегийн зорилт 5: Үндэсний стандартад олон улсын стандартын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Үндэсний стандартад олон улсын стандартын эзлэх хувь, хувь	40	42
Стратегийн зорилт 6: Техникийн зохицуулалт боловсруулахад төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлнэ.	Техникийн зохицуулалт, тоо	-	18
Стратегийн зорилт 7: Хэмжил зүйн салбарт зайлшгүй шаардлагатай улсын болон ажлын эталон бий болгоно.	Шинээр бий болсон улсын эталон, тоо	-	3
	Шинээр бий болсон ажлын эталон, тоо	-	6
Стратегийн зорилт 8: Эталоны шалгалт тохируулга, хэмжлийн чадавхаа үнэлүүлж олон улсад хүлээн зөвшөөрүүлнэ.	Хүлээн зөвшөөрөгдсөн хэмжлийн төрөл, тоо	1	4
Стратегийн зорилт 9: Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Тохирлын үнэлгээнд хамрагдсан байдал, хувь	40	80
	Аюулгүйн тэмдэг хэрэглэх эрхтэй бүтээгдэхүүний төрөл, тоо	3	30
Стратегийн зорилт 10: Үнэт металлын сорьцын хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.	Байгуулсан лаборатори, тоо	2	4
Стратегийн зорилт 11: Стандарт, хэмжил зүйн салбарын мэргэжилтэн бэлтгэх, чадавхжуулах тогтолцоог бүрдүүлнэ.	Салбарын хэмжээний сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр, тоо	-	2

**НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ**

Стратегийн зорилт	Шууд хэрэгжүүлэх нэгж	Дэмжлэг үзүүлэх нэгж
Стратегийн зорилт 1: Стандарт, хэмжил зүйн салбарын орлогыг нэмэгдүүлнэ.	Санхүүгийн асуудал хариуцсан нэгж	Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж, Аймгийн Стандарт, хэмжил зүйн салбар
Стратегийн зорилт 2: Стандарт, хэмжил зүйн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж	Зохион байгуулалтын нэгж, Аймгийн Стандарт, хэмжил зүйн салбар
Стратегийн зорилт 3: Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулна.	Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж	Зохион байгуулалтын нэгж
Стратегийн зорилт 4: Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж	Зохион байгуулалтын нэгж
Стратегийн зорилт 5: Үндэсний стандартад олон улсын стандартын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал хариуцсан нэгж	-
Стратегийн зорилт 6: Техникийн зохицуулалт боловсруулахад төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлнэ.		
Стратегийн зорилт 7: Хэмжил зүйн салбарт зайлшгүй шаардлагатай улсын болон ажлын эталон бий болгоно.	Хэмжил зүйн асуудал хариуцсан нэгж	Санхүүгийн асуудал хариуцсан нэгж, Аймгийн Стандарт, хэмжил зүйн салбар
Стратегийн зорилт 8: Эталоны шалгалт тохируулга, хэмжлийн чадавхаа үнэлүүлж олон улсад хүлээн зөвшөөрүүлнэ.		
Стратегийн зорилт 9: Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын асуудал хариуцсан нэгж, Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж	Аймгийн Стандарт, хэмжил зүйн салбар
Стратегийн зорилт 10: Үнэт металлын сорьцын хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.	Сорьцын хяналтын асуудал хариуцсан нэгж	Санхүүгийн асуудал хариуцсан нэгж, Аймгийн Стандарт, хэмжил зүйн салбар
Стратегийн зорилт 11: Стандарт, хэмжил зүйн салбарын мэргэжилтэн бэлтгэх, чадавхжуулах тогтолцоог бүрдүүлнэ.	Стандартын мэдээлэл лавлагаа, сургалтын асуудал хариуцсан нэгж	Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж

**ЕС. ХАВСРАЛТ**

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2020 он)	Зорилтот түвшин (2024 он)	Санхүүгийн эх үүсвэр
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: <b>Стандартчилал, хэмжил зүйн бодлого, зохицуулалт</b></i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: <b>Бодлого, стратегийн төлөвлөлт, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх</b></i>					
Стратегийн зорилт 1: Стандарт, хэмжил зүйн салбарын орлогыг нэмэгдүүлнэ.	Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлнэ.	Орлогын хэмжээ, төгрөг	860 сая	1.5 тэрбум	Улсын төсөв
	Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлнэ.		2.6 тэрбум	3.8 тэрбум	
	Сорьцын хяналтын үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлнэ.		2.9 тэрбум	4.0 тэрбум	
	Стандартын мэдээлэл лавлагаа, сургалтын орлогыг нэмэгдүүлнэ.		279 сая	500 сая	
Стратегийн зорилт 2: Стандарт, хэмжил зүйн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байрны асуудлыг шийдвэрлэх	Шинээр ашиглалтад орсон байр, тоо	-	3	Улсын төсөв, орон нутаг
	Орон нутгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн автомашины асуудлыг шийдвэрлэх	Худалдан авсан авто машин, тоо	-	10	
	Орон нутагт стандарт, хэмжил зүйн бүсийн төвүүдийг байгуулна.	Байгуулсан бүсийн төв, тоо	-	5	
	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад шаардлагатай санхүүгийн асуудлыг шийдвэрлэх	Хөрөнгө оруулалт, төгрөг	570 сая	1.2 тэрбум	
Стратегийн зорилт 3: Стандарт, хэмжил зүйн газраас үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулна.	<ul style="list-style-type: none"> <li>- Тохирлын ба тогтолцооны баталгаажуулалтын үйлчилгээ</li> <li>- Аюулгүйн тэмдэг олгох үйлчилгээ</li> <li>- Хэмжих хэрэгслийн загварын туршилтын үйлчилгээ</li> <li>- Хэмжил зүйн үйл ажиллагааны чадавхыг үнэлэх үйлчилгээ</li> </ul>	Цахим үйлчилгээний эзлэх хувь	20	100	Улсын төсөв

Стратегийн зорилт 4: Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Олон талт хамтын ажиллагааны хүрээнд олон улсын арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр
	Хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	5	
	Гишүүнээр элсэн орсон олон улсын байгууллагуудад Агентлагийн хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтийн судалгаа хийх, үр дүнг үнэлэх	Судалгаа, тоо	-	1	
	Олон улсын байгууллагын болон гадаад орны зээл, буцалтгүй тусламжийн төсөл, хөтөлбөрийн санал хүргүүлэх, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	Боловсруулсан төсөл хөтөлбөр, тоо	3	7	
<b>Үндсэн чиг үүргийн нэр: Стандартчилал, техникийн зохицуулалтын үйл ажиллагаа</b>					
Стратегийн зорилт 5: Үндэсний стандартад Олон Улсын стандартын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Газрын тосны салбарт шаардлагатай олон улсын 12-оос доошгүй стандартыг үндэсний болгоно	Үндэсний стандартаар батлагдсан олон улсын стандарт, хувь	40,3%	50%	Улсын төсөв
	Сэргээгдэх эрчим хүчний салбарт шаардлагатай 10-аас доошгүй олон улсын стандартыг үндэсний болгоно		33,3%	60%	
	Уул уурхай, ашигт малтмалын салбарт шаардлагатай 15-аас доошгүй олон улсын стандартыг үндэсний болгоно		35,3%	40%	
	ХАА, газар тариалангийн салбарт шаардлагатай 15-аас доошгүй олон улсын стандартыг үндэсний болгоно		10,4%	15%	
	Хүнсний салбарт шаардлагатай 20-аас доошгүй олон улсын стандартыг үндэсний болгоно		39,6%	40.1%	
Стратегийн зорилт 6: Техникийн зохицуулалт боловсруулахад дэмжлэг үзүүлэх;	Засгийн газрын 2019 оны 235 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх,	Батлагдсан техникийн зохицуулалт, тоо	5	23	Улсын төсөв

Үндсэн чиг үүргийн нэр: <b>Хэмжил зүйн бодлого, үйл ажиллагаа</b>					
Стратегийн зорилт 7: Хэмжил зүйн салбарт зайлшгүй шаардлагатай улсын болон ажлын эталон бий болгоно.	Цахилгаан, нягт, даралтын хэмжлийн төрлөөр улсын эталоныг шинээр бий болгоно.	Шинээр бий болсон улсын эталон, тоо	-	3	Улсын төсөв, Бусад эх үүсвэр
	Урт, эзэлхүүн, цахилгаан, масс, даралт, температурын хэмжлийн ажлын эталон шинээр бий болгоно.	Ажлын эталон, тоо	-	10	
	Хурд хэмжигч, хийн тоолуур шалгах ажлын 2 эталон шинээр бий болгож, шалгалт баталгаажуулалтын ажлын хүртээмжийг 10 %-иар нэмэгдүүлнэ.	Баталгаажуулалтын ажлын эталон, тоо	-	2	
	5 Аймгийн СХЗХ-ийн хэмжил зүйн техникийн чадавхыг бэхжүүлж, эзэлхүүн, уртын хэмжлийн төрлөөр хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг шинээр хийж, гүйцэтгэнэ.	Баталгаажуулалтын шинэ үйлчилгээ, тоо	-	2	
	5 хэмжлийн төрлөөр ажлын 50 эталон шинээр бий болгож, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын шинэ 5 үйлчилгээг 10 аймагт үзүүлнэ.	Шалгалт тохируулгын шинэ үйлчилгээ, тоо	-	5	
	Физик химийн 2 хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгад ашиглах 3 стандартчилсан загвар зохион бүтээдэг болно.	Стандартчилсан загвар, тоо	-	3	
Стратегийн зорилт 8: Эталоны шалгалт тохируулга, хэмжлийн чадавхиа үнэлүүлж олон улсад хүлээн зөвшөөрүүлнэ.	Цахилгаан, урт, даралтын хэмжлийн төрлөөр эталоны шалгалт тохируулга, хэмжлийн чадавхаа үнэлүүлэн олон улсад хүлээн зөвшөөрүүлж, хэмжил зүйн олон улс дахь статусаа 30%-иар нэмэгдүүлнэ.	Хүлээн зөвшөөрөгдсөн хэмжлийн төрөл, тоо	1	4	Улсын төсөв



<i>Үндсэн чиг үүргийн нэр: Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа</i>					
Стратегийн зорилт 9: Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх;	Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах	Тохирлын үнэлгээнд хамрагдсан бүтээгдэхүүн, хувь	50	80	Улсын төсөв
	Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлнэ;	Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний төрөл, тоо	4	10	
	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын нэр төрлийг нэмэгдүүлэх	Нэр төрөл, тоо	3	6	
	Орон нутагт менежментийн тогтолцооны баталгаажуулалт хийдэг болох	Аймгийн тоо	-	5	
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Үнэт металл, эрдэнийн чулуу, сорьцын хяналтын үйл ажиллагаа</i>					
Стратегийн зорилт 10: Үнэт металлын сорьцын хяналтын тогтолцоог бэхжүүлэх	Эрх зүйн орчныг шинэчлэх	Шинэчилсэн эрх зүйн акт, тоо	-	4	Улсын төсөв, Бусад эх үүсвэр
	Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэд сорьцын хяналтын лаборатори байгуулна.	Байгуулсан лаборатори, тоо	2	4	
	Эрдэнийн чулуу тодорхойлдог үзүүлэлтийн тоог нэмэгдүүлэх	Тодорхойлох үзүүлэлт, тоо	2	6	
	Эрдэнийн чулууны гэрчилгээг цахимаар харах боломжтой болгох, үнэт эдлэлийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан бий болгох	Бий болгосон мэдээллийн сан, тоо	-	1	
	Тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх	Шинээр бий болсон тоног төхөөрөмж, тоо	-	6	
	Орон нутгийн СХЗХ-т эрдэнийн чулууны төрлөөр үйлчилгээ үзүүлэх	Аймгийн тоо	-	5	
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Бусад үйл ажиллагаа</i>					